



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 02 өдөр

Дугаар 1/167

Хэрлэн сум

Тусгай зориулалтын авто замын түр чиглэл батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Авто замын тухай хуулийн 12 дугаар 12.1.5, 12.1.8, 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн Дархан сумын нутаг дахь Баргилтын ил уурхайгаас Бор-Өндөр сум дахь Бор-Өндөр УБҮ хүртэл 17 км уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлтийн тусгай зориулалтын авто замын түр чиглэлийн эргэлтийн цэгийг нэгдүгээр, маршрут зураглалыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Батлагдсан түр чиглэлийн дагуу сайжруулсан замын арчлалт хамгаалалтыг тогтмол хийж, хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган, тээвэрлэлтийн үйл ажиллагааг холбогдох хууль, дүрэм, журмын хүрээнд сайтар зохион байгуулж, ачаа тээвэрлэх үйл ажиллагааг гүйцэтгэн ажиллахыг "Монголросцветмет" ТӨҮГ-ын Бор-Өндөр уулын баяжуулах үйлдвэр-д үүрэг болгосугай.

3.Батлагдсан түр чиглэлийн дагуу бүтээгдэхүүн тээвэрлэлтийн замын хөдөлгөөний зохион байгуулалтад хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (Э.Жавхлантөгс)-т, Хэнтий аймаг дахь Авто тээврийн төв (Ц.Бат-Эрдэнэ)-д, Дархан сумын Засаг дарга (Ж.Энхтөр), Бор-Өндөр сумын Засаг дарга (Г.Адъяабилэгт) нарт тус тус даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Э.Мөнх-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны

09 дүгээр сарын 02 -ны өдрийн

дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

Дархан сумын нутаг дахь Баргилтын урхайгаас Бор-Өндөр УБҮ хүртэлх
17 км тусгай зориулалтын авто замын эргэлтийн цэг

Сумын нэр	Цэг №	Өргөрөг	Уртраг
Бор-Өндөр сум – 9.5 км	1	46°16'10.74"N	109°26'28.11"E
	2	46°16'18.09"N	109°26'7.35"E
	3	46°16'22.41"N	109°26'14.98"E
	4	46°16'31.40"N	109°25'59.57"E
	5	46°16'32.28"N	109°25'29.72"E
	6	46°16'38.39"N	109°25'11.84"E
	7	46°16'54.95"N	109°24'33.48"E
	8	46°17'21.72"N	109°23'46.39"E
	9	46°17'35.83"N	109°23'18.57"E
	10	46°17'47.03"N	109°22'3.68"E
	11	46°17'42.59"N	109°21'18.46"E
	12	46°18'0.78"N	109°20'49.64"E
	13	46°18'10.19"N	109°20'21.87"E
Дархан сум – 7.5 км	1	46°18'23.27"N	109°20'7.22"E
	2	46°18'33.79"N	109°19'44.56"E
	3	46°18'47.72"N	109°19'30.93"E
	4	46°18'57.61"N	109°19'4.56"E
	5	46°18'57.00"N	109°18'46.11"E
	6	46°18'47.61"N	109°18'27.49"E
	7	46°18'47.40"N	109°18'19.70"E
	8	46°18'48.54"N	109°18'14.87"E
	9	46°18'49.92"N	109°18'15.56"E
	10	46°18'52.95"N	109°18'9.71"E
	11	46°18'59.36"N	109°17'54.81"E
	12	46°19'5.82"N	109°17'47.35"E
	13	46°19'15.44"N	109°17'33.58"E
	14	46°19'21.41"N	109°17'27.39"E
	15	46°19'15.03"N	109°17'39.91"E
	16	46°19'22.28"N	109°17'29.86"E
	17	46°19'24.70"N	109°17'21.56"E
	18	46°19'34.51"N	109°17'4.85"E